| 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 2,418,776,150.79                | 993,480,780.28        | 3,489,081,421.87  | 6,901,338,352.94                       |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0                               | 0                     | 1,029,841.20      | 1,029,841.20                           |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 2,418,776,150.79                | 993,480,780.28        | 3,490,111,263.07  | 6,902,368,194.14                       |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0                               | -1,029,841.20         | 0                 | -1,029,841.20                          |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| Өмчид гарсан өөрчлөлт                           | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| Зарласан ногдол ашиг                            | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| Тайлант үеийн үр дүн                            | 0                               | 0                     | 287,861,964.92    | 287,861,964.92                         |
| 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 2,418,776,150.79                | 992,450,939.08        | 3,777,973,227.99  | 7,189,200,317.86                       |

2.5. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт   | Төлөвлөгөө              | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|--|-------------------------|-----------------------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>2,360,386,800.00</b> | <b>2,297,041,298.18</b>     |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>2,168,051,100.00</b> | <b>2,113,351,298.18</b>     |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>2,122,505,700.00</b> | <b>2,068,450,698.18</b>     |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>1,359,352,400.00</b> | <b>1,354,038,034.00</b>     |
| 210101      | Үндсэн цалин   | 1,050,258,300.00        | 1,040,057,567.00            |
| 210102      | Нэмэгдэл   | 156,080,400.00          | 167,216,556.00              |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 5,544,000.00            | 4,503,000.00                |
| 210104      | Урамшуулал   | 85,147,500.00           | 80,073,178.00               |
| 210105      | Гэрээт ажлын хөлс  | 62,322,200.00           | 62,187,733.00               |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>183,978,400.00</b>   | <b>174,706,312.18</b>       |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 129,466,300.00          | 122,367,672.37              |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 13,628,100.00           | 13,691,056.95               |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 10,902,200.00           | 10,960,407.86               |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 2,725,800.00            | 2,557,072.45                |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 27,256,000.00           | 25,130,102.55               |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>278,397,600.00</b>   | <b>263,025,345.00</b>       |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 22,903,300.00           | 20,659,141.00               |
| 210302      | Түлш, халаалт  | 254,874,300.00          | 242,366,204.00              |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 620,000.00              | 0                           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>106,107,900.00</b>   | <b>104,474,290.00</b>       |
| 210401      | Бичиг хэрэг  | 6,933,600.00            | 6,344,950.00                |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 60,053,400.00           | 60,693,660.00               |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 8,439,200.00            | 6,797,200.00                |
| 210404      | Ном, хэвлэл  | 1,093,300.00            | 504,300.00                  |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 5,702,300.00            | 4,875,700.00                |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 23,886,100.00           | 25,258,480.00               |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>98,257,200.00</b>    | <b>92,013,280.00</b>        |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 29,140,700.00           | 29,064,710.00               |
| 210502      | Хоол, хүнс   | 66,381,600.00           | 60,678,570.00               |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 2,734,900.00            | 2,270,000.00                |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>32,298,700.00</b>    | <b>31,866,710.00</b>        |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 4,800,700.00            | 4,800,000.00                |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 1,083,300.00            | 1,041,000.00                |
| 210604      | Урсгал засвар  | 26,414,700.00           | 26,025,710.00               |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>10,382,100.00</b>    | <b>5,669,000.00</b>         |
| 210702      | Дотоод албан томилолт  | 10,382,100.00           | 5,669,000.00                |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>8,505,900.00</b>     | <b>5,038,365.00</b>         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,043,400.00            | 470,000.00                  |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,886,400.00            | 1,886,400.00                |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 452,600.00              | 246,600.00                  |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 429,500.00              | 264,786.00                  |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 201,000.00              | 33,000.00                   |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 2,253,000.00            | 1,912,000.00                |
| 210807      | Газрын төлбөр  | 240,000.00              | 225,579.00                  |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>45,225,500.00</b>    | <b>37,619,362.00</b>        |

|             |   |                         |                         |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 33,177,800.00           | 27,475,462.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                             | 12,047,700.00           | 10,143,900.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                       | <b>45,545,400.00</b>    | <b>44,900,600.00</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                 | <b>45,545,400.00</b>    | <b>44,900,600.00</b>    |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                      | 42,463,800.00           | 42,463,100.00           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                       | 3,081,600.00            | 2,437,500.00            |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                       | <b>112,335,700.00</b>   | <b>103,690,000.00</b>   |
| 223001      | Бусад хөрөнгө   | 112,335,700.00          | 103,690,000.00          |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>             | <b>80,000,000.00</b>    | <b>80,000,000.00</b>    |
| 230001      | Эргэж төлөгдөх зээл   | 80,000,000.00           | 80,000,000.00           |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                         | <b>2,360,386,800.00</b> | <b>2,285,542,915.91</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>1,436,558,000.00</b> | <b>1,425,473,212.93</b> |
| 310003      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                      | 1,340,222,300.00        | 1,329,137,598.93        |
| 310004      | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих               | 96,335,700.00           | 96,335,614.00           |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                         | <b>801,395,800.00</b>   | <b>771,197,241.98</b>   |
| 320001      | Орон нутгийн төсвөөс  | 801,395,800.00          | 771,197,241.98          |
| <b>33</b>   | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>           | <b>22,913,200.00</b>    | <b>18,530,760.00</b>    |
| 330002      | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                     | 22,913,200.00           | 18,530,760.00           |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                  | <b>99,519,800.00</b>    | <b>70,341,701.00</b>    |
| 350001      | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                     | 35,000,000.00           | 70,341,701.00           |
| 350003      | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                                 | 64,519,800.00           | 0                       |
| 4           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл              | 0                       | 88,278,997.28           |
| 5           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл             | 0                       | 79,480,615.01           |
| <b>6</b>    | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                       | <b>753</b>              | <b>751</b>              |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                       | <b>6</b>                | <b>6</b>                |
| 610001      | Төсвийн байгууллага   | 6                       | 6                       |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>  | <b>116</b>              | <b>115</b>              |
| 620001      | Удирдах ажилтан   | 11                      | 11                      |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан   | 70                      | 69                      |
| 620003      | Үйлчлэх ажилтан   | 24                      | 24                      |
| 620004      | Гэрээт ажилтан  | 11                      | 11                      |
| <b>63</b>   | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>                     | <b>515</b>              | <b>515</b>              |
| <b>630</b>  | <b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>              | <b>404</b>              | <b>404</b>              |
| 630001      | Төрийн өмчит ЕБС  | 404                     | 404                     |
| <b>631</b>  | <b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>               | <b>111</b>              | <b>111</b>              |
| 631001      | Төрийн өмчит СӨБ байгууллага                                  | 111                     | 111                     |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                    | <b>116</b>              | <b>115</b>              |
| 650001      | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                            | 10                      | 10                      |
| 650004      | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)           | 43                      | 42                      |
| 650006      | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4                       | 4                       |
| 650008      | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16                      | 16                      |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                    | 30                      | 30                      |
| 650010      | Гэрээт ажилтан  | 7                       | 7                       |
| 650011      | Улс төрийн албан хаагч (УТ)                                   | 6                       | 6                       |

**2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт   | ТЗ цэвэр дүн          |
|-------------|--|-----------------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>164,879,460.87</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>134,879,460.87</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>107,279,460.87</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>36,300,292.00</b>  |
| 210101      | Үндсэн цалин   | 32,800,792.00         |
| 210104      | Урамшуулал   | 3,499,500.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>8,179,898.87</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 7,729,358.37          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 119,545.70            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 95,636.54             |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 21,396.22             |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 213,962.04            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>8,693,215.00</b>   |
| 210401      | Бичиг хэрэг  | 630,521.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 6,148,694.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 334,000.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 670,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 910,000.00            |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>35,652,145.00</b>  |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 31,405,210.00         |
| 210502      | Хоол, хүнс   | 4,246,935.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>11,769,500.00</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 1,250,000.00          |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 10,519,500.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>383,410.00</b>     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 283,410.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 100,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>6,301,000.00</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 3,750,000.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 2,551,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>27,600,000.00</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>27,600,000.00</b>  |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 27,600,000.00         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>30,000,000.00</b>  |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>30,000,000.00</b>  |
| 223001      | Бусад хөрөнгө  | 30,000,000.00         |
| <b>I</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>172,853,575.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>172,853,575.00</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 3,700,000.00          |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,409,704.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 132,743,871.00        |
| <b>III</b>  | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  | <b>7,974,114.13</b>   |
| 10          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 7,974,114.13          |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Бөхмөрөн сумын Засаг дарга нь "Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуулчлал хөгжсөн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан бүхий, хүний хөгжлийг дээдэлсэн, чинээлэг иргэдтэй сум болно" гэсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Бөхмөрөн сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 27.7 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,468.6 сая төгрөгийн 1 хувь буюу 34.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 27.7 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бөхмөрөн сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 304.2 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

|  |                |               | /сая.төгрөг/ |
|--|----------------|---------------|--------------|
| Мөнгөн хөрөнгө                             | 170.9          | 398.7         | 227.8        |
| Авлага                                     | 172.7          | 269.4         | 96.8         |
| Урьдчилгаа                                 | 0.0            | 0.0           | 0.0          |
| Бараа материал                             | 164.8          | 199.9         | 35.2         |
| Үндсэн хөрөнгө                             | 6,405.8        | 6350.2        | -55.5        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                  | <b>6,914.1</b> | <b>7218.3</b> | <b>304.2</b> |
| Нийт өр төлбөр                             | 12.8           | 29.1          | 16.3         |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн                   | 6,901.3        | 7189.2        | 287.9        |
| Засгийн газрын хувь оролцоо                | 6,901.3        | 7189.2        | 287.9        |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>6,914.1</b> | <b>7218.3</b> | <b>304.2</b> |

Эх сурвалж: Бөхмөрөн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 398.7 сая төгрөг болж 227.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 269.4 сая төгрөг болж 96.8 сая төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 199.9 сая төгрөг болж 35.2 сая төгрөгөөр өссөн нь Соёлын төв, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,350.2 сая төгрөг болж 55.5 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,189.2 сая төгрөг болж 287.9 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 309.1 сая төгрөгөөр буюу 7.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 222.5 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.5.5 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 311.8 сая, татварын бус орлого 341.0 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,230.2 сая, нийт 3,883.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.5.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 10.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Бөхмөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:

- Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулахаар заасан ч Цагдаагийн хэсгийн тээврийн хэрэгслийн сэлбэгийн зардалд 0.3 сая төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар:

- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасныг зөрчин 0.8 сая төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

- Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох шийдвэр гаргахдаа хүчингүй болсон Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолыг үндэслэсэн зөрчилд Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургууль:

- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасныг зөрчин 0.1 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төв:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 зүйлийн 20.1.4 дэх заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчиж 9.2 сая төгрөгийн 3996 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

- Хөрөнгө зарцуулсан тушаалууд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй зөрчилд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг мөрдөж ажиллах, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажил дүгнэсэн үнэлгээтэй уялдуулаагүй зөрчилд Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралтын 2.5-д "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж тус тус өглөө.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Бөхмөрөн сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/11 дүгээр тогтоолоор 2,704.4 сая төгрөгөөр баталж 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 4/05 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 344.0 сая төгрөгөөр бууруулж 2,360.4 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,360.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1,436.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 801.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 99.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,425.5 сая, орон нутгийн төсвөөс 771.2 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18.5 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 70.3 сая, нийт 2,285.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,297.0 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 11.1 сая, орон нутгийн төсөвт 39.3 сая, нийт 50.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,297.0 сая төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь зардлыг 50.4 сая төгрөгөөр хэмнэж, гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 4.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгдэж, Эрүүл мэндийн төвийн дансанд 7.5 сая төгрөг үлдэж, Сум хөгжүүлэх сангийн батлагдсан төсвөөс 1.4 сая, ОНХС-ийн батлагдсан төсвөөс 8.6 сая төгрөгийг дутуу зарцуулж, ЗДТГ-т илүү олгосон санхүүжилт 4.0 сая төгрөгийг төвлөрүүлж, Байгаль хамгаалах сангийн дансны үлдэгдэл 5.0 сая төгрөгийг ЗДТГ-т нэгтгэсэнтэй холбоотой байна.

Бөхмөрөн сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 04/05 дугаар тогтоолд зааснаар Бөхмөрөн сумын Засаг дарга тайлант онд 54.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 319.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 584.2 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 36.4 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 3.7 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 132.7 сая, нийт 172.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 164.9 сая төгрөгийг зарцуулж Эрүүл мэндийн төв 7.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Бөхмөрөн сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 115, хугацаа хоцроож 40 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 77.0 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар**

Бөхмөрөн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 10.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10.3 төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д        | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |             | Үүнээс    |     |               |            |                 |             |          |            |
|------------|-------------------------------------|----------------------|-------------|-----------|-----|---------------|------------|-----------------|-------------|----------|------------|
|            |                                     |                      |             | Залруулга |     | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |             | Зөвлөмж  |            |
|            |                                     | Тоо                  | Дүн         | Тоо       | Дүн | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн         | Тоо      | Дүн        |
| 1          | ИТХ                                 | 1                    | 0.3         |           |     |               |            | 1               | 0.3         |          |            |
| 2          | ЗДТГ                                | 2                    | 0.8         |           |     |               |            | 1               | 0.8         | 1        | 0.0        |
| 3          | ЕБС                                 | 1                    | 0.1         |           |     | 1             | 0.1        |                 |             |          |            |
| 4          | ЭМТ                                 | 3                    | 9.2         |           |     |               |            | 1               | 9.2         | 2        | 0.0        |
| <b>Дүн</b> |                                     | <b>7</b>             | <b>10.4</b> |           |     | <b>1</b>      | <b>0.1</b> | <b>3</b>        | <b>10.3</b> | <b>3</b> | <b>0.0</b> |

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

| №           | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |            | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|-------------|-------------------------------------|----------------------|------------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|             |                                     |                      |            | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|             |                                     | Тоо                  | Дүн        | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1           | Бөхмөрөн сумын Засаг дарга          | 0                    | 0.0        |           |     |               |     |                 |     |         |     |
| <b>НИЙТ</b> |                                     | <b>0</b>             | <b>0.0</b> |           |     |               |     |                 |     |         |     |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2022 оны 03 сарын 21-ний өдөр